

**Санхүүгийн тайлангийн аудитын хураангуй
тайлан**

Огноо: 2021.03.30

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	ТӨА- 2021/9/СТА- ТТЗ	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Төв аймгийн Лүн сумын ТТЗ
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Төв аймаг дахь Төрийн аудитын газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан	Аудитор Т.Хүрэлбаатар
Аудитын нэр:	Төв аймгийн Лүн сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит		

Хоёр. Байгууллага, нэгжийн тоо болон санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудит хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Итгэл үзүүлсэн	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Төв аймгийн Лүн сумын ТТЗ	1	+				+			
	ДҮН	1	+				+			

Гурав. Аудитын үр дүн

2.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс			
		Тоо	Дүн	Зөвлөмж	Төлбөрийн акт	Албан шаардлага	Залруулсан
A	1	2	3	4	5	6	7
1	Лүн сумын ТТЗ	1	18,127.1	18,127.1			
	ДҮН	1	18,127.1	18,127.1			

2.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ач холбогдлоор нь эрэмбэлж танилцуулах:

Алдаа, зөрчилтэй асуудал 1

Сумын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ биелсэн боловч 8 төрлийн орлогын төлөвлөгөө 18,127.1 мянган төгрөгөөр тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн: Зөвлөмж өгөв.

Санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдлийг аймгийн ХХААГ-ийн ирүүлсэн авлагын үлдэгдэлтэй тулгахад 12,571.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн: Зөвлөмж өгөв.

2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 40 иргэнтэй холбоотой 253,850.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй. Үүнээс 34 иргэнтэй холбоотой 139,213.7 мянган төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн ба 3,128.7 мянган төгрөгийн 1 иргэний авлагыг шүүхэд шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-д "Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэхэд дараах шаардлага тавигдана", 39.4.2-д "өр, авлага үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", ЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 3.5.3-д "энэ журмын 3.5.2-т заасан төслийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээдтэй зохих журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, явц, үр дүнд байнгын хяналт тавьж ажиллах" гэсэн заалтыг болон санхүүгийн аудитын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

Сумын ИТХ-ын 2019.12.19-ний 06 тоот тогтоолоор үйл ажиллагааны зардалд 2020 онд санд орох нийт хүүгийн 20% хүртэлх төгрөгийг зарцуулж болно гэж баталсан байна. Хүүгийн орлого 5,544.5 мянган төгрөг, гүйцэтгэлээр 9,440.0 мянган төгрөг зарцуулж 8,331.1 мянган төгрөг хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 5

дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 16 дугаар зүйлийн 16.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, ЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 1.8-д “Сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан зарцуулна” гэсэн заалтыг болон санхүүгийн аудитын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

ОНХС-ийн эхний үлдэгдэл 62,595.6 мянган төгрөг, олон улсын төсөл хөтөлбөрөөс 41,558.3 мянган төгрөг, тогтвортой амьжиргаа 3 төслөөс урамшуулал 12,434.4 мянган төгрөг, дэмжлэг 8,542.5 мянган төгрөг, нийт 125,130.8 мянган төгрөгийн санхүүжилт авсан 105,923.0 мянган төгрөгийн зардал гаргаж 19,205.8 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй тайлагнасан. ОНХС-ийн дансны эхний үлдэгдэл 62,595.6 мянган төгрөгийг сумын ИТХ-ын 2019.12.19-ний өдрийн 05 дугаар "Сумын 2020 оны төсөв батлах тухай" тогтоолд 51,160.7 мянган төгрөг гэж 11,434.9 мянган төгрөгөөр дутуу баталсан нь санхүүгийн тайлангийн аудитын "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн: Зөвлөмж өгөв.

2.3 Аудитын санал дүгнэлтийн үндэслэл:

Төв аймгийн Лүн сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг түвшингөөс хэтрээгүй тул **Зөрчилгүй** санал дүгнэлт өгөхөөр шийдвэрлэсэн.

Дөрөв. Баталгаажуулалт

Тайлангийн хураангуй бэлтгэсэн:

Аудитор

Анхан шатны чанарын хяналт хийсэн:

Аудитын менежер

Танилцаж зөвшөөрсөн:

Дарга, тэргүүлэх аудитор



Т.Хүрэлбаатар

О.Амаржаргал

Ц.Хишигжаргал